

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

Аудитын код: ХОА-2021/99/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Ховд хот
2021 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn
Гэрээт аудитор: Б.Бадамцэцэг
Утас: 70432545

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ЗДТГ</i>	<i>Засаг даргын дамгын газар</i>
<i>ОНХС</i>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>
<i>БҮТЭЗ</i>	<i>Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл</i>
<i>ИТХ</i>	<i>Иргэдийн төлөөлөгчдийн хурал</i>

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН.....	5
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	7
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	9
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	9
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН	9
3.АУДИТЫН ТАЙЛАН	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	16
.....	Error! Bookmark not defined.
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	16
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	17

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА С.ХОРОЛСҮРЭН ТАНАА

2021.02.24 № 2/23
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, төр иргэнийг холбосон бүртгэлийн үйлчилгээ зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Үнэт цаасны орлого, бараа материалын худалдан авалт, зарцуулалтад тавих хяналт сул, албан хаагчдад олгох тэтгэмж, цалин амралтыг зөрүүтэй тооцсон, анхан шатны баримтын бүрдүүлэлт бүрэн бус, санхүүгийн тайлан дахь тоон мэдээллүүд зөрүүтэй илэрхийлэгдсэн зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 -д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчиж Оршин байх, Тохилдсон байх, Иж бүрэн байх, Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал мэдэгдлийг хангахгүй байна.

021020492

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>47381507,91</u>	<u>55430221,08</u>
33	АВЛАГА	0,00	86076,02
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		86076,02
35	БАРАА МАТЕРИАЛ	47381507,91	55344145,06
351	Түүхий эд материал	18897049,20	23319346,35
35110	Тусгай зориулалттай материал	18897049,20	23319346,35
35300	Бэлэн бүтээгдэхүүн	860450,00	4136190,00
354	Хангамжийн материал	27624008,71	27888608,71
35410	Бичиг хэргийн материал	2823900,00	3128500,00
35420	Аж ахуйн материал	24800108,71	24760108,71
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>40538447,08</u>	<u>29328256,36</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	40538447,08	29328256,36
391	Газар		
392	Биет хөрөнгө	40538447,08	29328256,36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14100000,00	14100000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	1410000,00	4230000,00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	229311057,65	231950057,65
39206	Хуримтлагдсан элэгдэл	216267424,69	223764508,77
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43619970,00	43619970,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	28815155,88	32347262,52
39301	Програм хангамж	5419900,00	5419900,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	5419900,00	5419900,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>87919954,99</u>	<u>84758477,44</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>87919954,99</u>	<u>84758477,44</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	87919954,99	84758477,44
512	Хуримтлагдсан үр дүн	87919954,99	84758477,44
51210	Өмнөх үеийн үр дүн	87919954,99	87919954,99
51220	Тайлант үеийн үр дүн		-3161477,55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>87919954,99</u>	<u>84758477,44</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	538484282,36	759610471,53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14752582,36	26142171,53
120	Нийтлэг татварын бус орлого	14752582,36	26142171,53
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14752582,36	26142171,53

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	14752582,36	26142171,53
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	523731700,00	733468300,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	509631700,00	572658800,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	509631700,00	572658800,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14100000,00	160809500,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14100000,00	160809500,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	537790686,87	762771949,03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	537790686,87	762771949,03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	536670686,87	758922599,89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	414347700,00	470905550,62
210101	Үндсэн цалин	325239000,00	435836750,62
210102	Нэмэгдэл	67460700,00	30184800,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21648000,00	4884000,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50607467,20	61716007,22
210201	Тэтгэврийн даатгал	33520117,00	38727313,37
210202	Тэтгэмжийн даатгал	3369916,20	5639691,83
210203	ҮОМШӨ-ний даатгал	4047633,00	4794131,06
210204	Ажилгүйдлийн даатгал	1428071,00	1141569,18
210205	Эрүүл мэндийн даатгал	8241730,00	11413301,78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14383600,00	14394100,00
210301	Гэрэл, цахилгаан	231000,00	362200,00
210302	Түлш, халаалт	2227900,00	2818100,00
210303	Цэвэр, бохир ус	164000,00	2245000,00
210304	Байрны түрээс	11760700,00	8968800,00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	23779830,00	22741798,00
210401	Бичиг хэрэг	8803000,00	13192011,00
210402	Тээвэр, шатахуун	3484800,00	2856800,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5255500,00	3661687,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	50000,00	31200,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2160000,00	3000100,00
210408	Бараа материал акталсны зардал	4026530,00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2980000,00	2352938,90
210601	Багаж, техник, хэрэгсэл	1080000,00	697200,00
210602	Тавилга		1525738,90
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	400000,00	
210604	Урсгал засвар	1500000,00	130000,00
2107	Томилолт, зочны зардал	3581000,00	1096000,00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	3581000,00	1096000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15628921,40	13501346,80

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800000,00	650000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		432000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51900,00	82429,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		22000,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	14777021,40	12314917,80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11362168,27	172214858,35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		160806501,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2296000,00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9066168,27	11408357,35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1120000,00	3849349,14
2132	Бусад урсгал шилжүүлэг	1120000,00	516000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1120000,00	516000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0,00	3333349,14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		3330350,14
213306	Улсын төсвийн ордогод төвлөрүүлэх орлого		2999,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>693595,49</u>	<u>-3161477,50</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>693595,49</u>	<u>-3161477,50</u>

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>687017412,40</u>	<u>878088574,00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>163285712,40</u>	<u>144620274,00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	163285712,40	144620274,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	163285712,40	144620274,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	163285712,40	144620274,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>523731700,00</u>	<u>733468300,00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	509631700,00	572658800,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	509631700,00	572658800,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14100000,00	160809500,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14100000,00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		160809500,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>672917412,40</u>	<u>878088574,00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>672917412,40</u>	<u>878088574,00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>508511700,00</u>	<u>729618950,86</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	414347700,00	451527897,68

210101	Үндсэн цалин	325239000,00	378913249,68
210102	Нэмэгдэл	67460700,00	62384148,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21648000,00	10230500,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50458200,00	81179736,18
210201	Тэтгэврийн даатгал	33974750,00	64688381,52
210202	Тэтгэмжийн даатгал	3369916,00	4135342,20
210203	ҮОМШӨ-ний даатгал	4047633,00	3307872,94
210204	Ажилгүйдлийн даатгал	824171,00	820372,71
210205	Эрүүл мэндийн даатгал	8241730,00	8227766,81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14383600,00	14394100,00
210301	Гэрэл, цахилгаан	231000,00	336000,00
210302	Түлш, халаалт	2227900,00	2818100,00
210303	Цэвэр, бохир ус	164000,00	240000,00
210304	Байрны түрээс	11760700,00	11000000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	19613300,00	17661687,00
210401	Бичиг хэрэг	8663000,00	8726900,00
210402	Тээвэр, шатахуун	3484800,00	2808800,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5255500,00	3867187,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	50000,00	31200,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2160000,00	2227600,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2980000,00	1796600,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1080000,00	800200,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	400000,00	866400,00
210604	Урсгал засвар	1500000,00	130000,00
2107	Томилолт, зочны зардал	3581000,00	1096000,00
210702	Дотоод албан томилолт	3581000,00	1096000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	851900,00	1156429,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800000,00	620000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		432000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51900,00	82429,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		22000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2296000,00	160806501,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		160806501,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2296000,00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	164405712,40	148469623,14
2132	Бусад урсгал шилжүүлэг	1120000,00	516000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1120000,00	516000,00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	163285712,40	147953623,14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		3330350,14
213306	төвлөрүүлэх шилжүүлэг	163285712,40	144623273,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>14100000,00</u>	<u>0,00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14100000,00	0,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14100000,00	0,00
2200	Дотоод эх үүсвэрээр	14100000,00	0,00
222001	Тоног төхөөрөмж	14100000,00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-14100000,00</u>	<u>0,00</u>

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	87 919 954,99	87 919 954,99
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	87 919 954,99	87 919 954,99
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	87 919 954,99	87 919 954,99
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	87 919 954,99	87 919 954,99
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	87 919 954,99	87 919 954,99
D08	Тайлант үеийн үр дүн	-3 161 477,55	-3 161 477,55
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	84 758 477,44	84 758 477,44

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	572658800,00	569328449,86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	572658800,00	569328449,86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	572142200,00	568812449,86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	452 069 300,00	451 527 897,68
210101	Үндсэн цалин	381 931 300,00	378 913 249,68
210102	Нэмэгдэл	60 370 000,00	62 384 148,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9 768 000,00	10 230 500,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83890400,00	81179736,18
210201	Тэтгэврийн даатгал	66 115 900,00	64 688 381,52
210202	Тэтгэмжийн даатгал	4 443 600,00	4 135 342,20

210203	ҮОМШӨ-ний даатгал	3 554 900,00	3 307 872,94
210204	Ажилгүйдлийн даатгал	888 700,00	820 372,71
210205	Эрүүл мэндийн даатгал	8 887 300,00	8 227 766,81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14461600,00	14394100,00
210301	Гэрэл, цахилгаан	336 000,00	336 000,00
210302	Түлш, халаалт	2 885 600,00	2 818 100,00
210303	Цэвэр, бохир ус	240 000,00	240 000,00
210304	Байрны түрээс	11 000 000,00	11 000 000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	17671100,00	17661687,00
210401	Бичиг хэрэг	8 726 900,00	8 726 900,00
210402	Тээвэр, шатахуун	2 808 800,00	2 808 800,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3 867 200,00	3 867 187,00
210404	Ном, хэвлэл	37 000,00	00,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00,00	31 200,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2 231 200,00	2 227 600,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1797300,00	1796600,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	800 500,00	800 200,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	866 800,00	866 400,00
210604	Урсгал засвар	130 000,00	130 000,00
2107	Томилолт, зочны зардал	1096000,00	1096000,00
210702	Дотоод албан томилолт	1 096 000,00	1 096 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1156500,00	1156429,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	620 000,00	620 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432 000,00	432 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	82 500,00	82 429,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22 000,00	22 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0,00	0,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00,00	00,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	516600,00	516000,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	516 600,00	516 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	516 600,00	516 000,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	569 328 449,86	569 328 449,86
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	569 328 449,86	569 328 449,86
131001	Улсын төсвөөс санхүүжих	569 328 449,86	569 328 449,86

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	160809500,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	160809500,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	160806501,00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	160806501,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	160806501,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2999,00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2999,00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2999,00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	160809500,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	160809500,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160809500,00

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг хэлтсийн дарга С.Хоролсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд дотоод хяналтыг хэрэгжүүлэн, төсвийн зарцуулалтад хяналт тавих, И баримттай бараа материал худалдан авч хэвших, шилэн дансны хэрэгжилтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 28-наас 2021 оны 02 дугаар сарын 19-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Б.Бадамцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь “Төрийн бүртгэл үйлчилгээг ард иргэдэд шударга, ил тод шуурхай хүргэж, төр иргэнийг холбосон бүртгэлийн үйлчилгээгээр иргэний үүргийг дээшлүүлж эрхийг хангах” гэсэн эрхэм зорилгыг сахилга хариуцлагыг эрчимжүүлэх, ногоон эдийн засгийг дэмжих гэсэн зорилтыг үйл ажиллагаатайгаа уялдуулахад чиглүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-нд батлагдсан Журам батлах тухай 382 дугаар тогтоолыг 2020 оны 01-р сарын 1-нээс мөрджээ.

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Улсын бүртгэлийн хэлтэс санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын алба байгуулаагүй, дотоод аудитын нэгжгүй, хяналт хэрэгжүүлсэн талаар ажлын тайлан ирүүлээгүй болно.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр **нийт зардлыг** сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 538484,3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 5384.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 759610.5 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 7596.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3161.4 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	0,0	86.1	86.1
БАРАА МАТЕРИАЛ	47,381.5	55,344.1	7,962.6
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	40,538.4	29,328.3	(11,210.2)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	87,919.9	84,758.5	-3,161.4
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	0	0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	87,919.9	84,758.5	3161,4
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	410,120.6	394,363.6	-3161.4

Авлага дансны үлдэгдэл 86.1 мянган төгрөг болж өссөн шалтгаан нь тус хэлтсийн тооцооллын алдаатай ХХОАТ-ыг илүү төлсөнтэй холбоотой үүссэн бөгөөд энэ авлага бүрэн барагдах боломжтой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 55344,1 мянган төгрөг болж 7962.6 мянган төгрөгөөр өссөн нь бичгийн цаас, принтерийн хор олноор нөөцөлсөн, УБЕГ-аас үнэ төлбөргүй үнэт цаас ирснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 40538.4 мянган төгрөг, оны эцэст 29328.3 мянган төгрөг болж 11210.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь Улсын бүртгэлийн ерөнхий газраас оруулалтаар хөрөнгө оруулалтаар 2639,0 мянган төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмжийг хандиваар авч, нийт 2639.0 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэн байна.

Өр төлбөр оны эхэнд 0 мянган төгрөг, оны эцэст үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 87919,9 мянган төгрөг, оны эцэст 84758.9 мянган төгрөг болж 3161,5 мянган төгрөгөөр буурсан байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 221126,2 мянган төгрөгөөр буюу 41.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 221126.2 мянган төгрөгийн орлогоос 63027.1 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, 11389.6 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлого нэмэгдсэн, 146709.5 мянган төгрөгөөр нэмэлт санхүүжилтийн орлого өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 224981.2 мянган төгрөгөөр буюу 41.8 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 64175.7 мянган төгрөг буюу 28.5 хувиар, бараа үйлчилгээний зардал 160806,5 мянган төгрөг буюу 71.5 хувиар дээрх зардлууд өссөн байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн, УИХ-ын болон аймаг сумын ИТХ-ын сонгуулийг аймаг орон нутагтаа зохион байгуулж ажилласантай холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 572658,8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 572658,8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 572658,8 мянган төгрөгийн төсөв баталснаас 572658,8 мянган төгрөгийг Улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Үндсэн үйл ажиллагааны орлогоос 144620,3 мянган төгрөгийн орлого оруулж, УБЕГ-т төвлөрүүлжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 572658,8 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 572658,8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 569328,4 мянган төгрөгийг зарцуулж 3330,4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	3329,8
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	0,6
	ДҮН	3330,4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансаар 160809,5 мянган төгрөгийн санхүүжилт авч 160806,6 мянган төгрөгийг зарцуулж 2,9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулсан 135 мэдээлэл, 1 мэдээллийг хугацаа хоцроож, 10 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны мэдээллээс эрсдэлтэй гэж үзсэн гүйлгээг хянахад 08 дугаар сарын тухай бүрд мэдээлэх 10 ажил гүйлгээ буюу нэмэлт санхүүжилтийн орлого зарлагын мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3744.7 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	3744.7	1	3744.7	-	-	100
Зөвлөмж	1		0		1		0
Нийт дүн	2	3744.7	2	3744.7	1		50

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11181.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 198,2 мянган төгрөгийн алдааг залруулж, 4345,4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгч, 5469.7 мянган төгрөгийн акт тогтоож, 1168.5 мянган төгрөгийг буцаан олгох акт тогтоолоо.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй тоног төхөөрөмж ирсэнтэй холбоотой элэгдлийн зардлын 198.2 мянган төгрөгийн алдаа байна

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 198,2 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 10983.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 6638.2 мянган төгрөгийг буцаан олгох акт тогтоож, 4345.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант онд албан хаагчдад цалингийн урьдчилгаа олгоод суутгаагүй, сахилгын арга хэмжээг дутуу суутгасан, үнэт цаасны тооцоог бодсон боловч сумдын улсын бүртгэгч нараас орлого дутуу төвлөрүүлж, авлагаар бүртгээгүйтэй холбоотой 1398.8 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” Орон нутгийн төрийн өмчийн тухай хуулийн 70-р зүйлийн 3-д ... үнэт цаасны тооллогыг улиралд 1 удаа / улирлын эцсийн сарын 25-наас /; 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; гэсэн заалттай нийцэхгүй, аудитын “үнэн зөв байдал”, “бодитой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт бичих

2. Тус хэлтэс нь төрийн албан хаагчийн өндөр насны тэтгэвэрт гарахад төрийн албанд ажилласан жилийг буруу тооцож тэтгэмж илүү олгосон 4070.9 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь ЗГ-ын 2019 оны 7 дугаар тогтоолын 2.2-д “өндөр насны тэтгэвэр тогтоолгосон төрийн албан хаагчид 2.1-д зааснаар үндсэн цалингийн дунджийг нь төрийн албанд ажилласан нийт жилийн тоотой тэнцэх сарын тоогоор үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно”, 5.4. Төрийн албан хаагчийн ажиллаж байсан байгууллагын дарга, хүний нөөц болон санхүү хариуцсан ажилтнууд энэ журмын дагуу тухайн төрийн албан хаагчийн төрийн алба хаасан хугацаа, үндсэн цалинг үнэн зөв тодорхойлох үүрэг хүлээнэ, гэсэн заалттай нийцэхгүй, аудитын “үнэн зөв байдал”, “бодитой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт бичих

3. Тайлант онд 3 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад нь ээлжийн амралтын тооцоо хийж, амралтын цалин бодож олгоогүйтэй холбоотой 1168.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх. гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах гэсэн заалттай нийцэхгүй, аудитын “үнэн зөв байдал”, “бодитой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Буцаан олгох төлбөрийн акт бичих

3. 2020 онд нийт 2808,8 мянган төгрөгийн шатах тослох материал худалдан авсан боловч зарцуулалтын тайлан гаргаагүй, төлбөрийг төлөхдөө бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэх, бусад нотлох баримтгүй ажил гүйлгээ хийгдсэн, жолоочийн тооцооны хуудсыг жолооч нар нь тухайн сард авсан шатахуундаа тааруулан км бичсэн, нягтлан бодогч нь жолоочийн замын хуудсыг хаана хэний зөвшөөрлөөр ажилласныг тулган баталгаажуулж тооцоог сар бүр, бодоогүй, бичиг хэргийн материалыг хяналтгүй, зориулалт бусаар зарцуулж, сард 50 боодол цаас, 15 ш принтерийн хорыг зарцуулсан 1536,6 мянган төгрөгийн нийт 4345,4 мянган төгрөгийн төсвийн үргүй зардал гаргасан нь НББ-ийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.5 дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 15-д Хариуцаж байгаа эд зүйлийг зохих хууль ёсны баримт материал бүрдсэн буюу удирдлагын шийдвэрээр зориулагдсан зүйлд нь өөрийн биеэр тавьж олгож, хяналт тавьж ажиллана, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 17-д Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид өгч байна, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, аудитын “үнэн зөв байдал”, “бодитой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 4345.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага бичих

Аудитын зөвлөмж:

Аудитаар илэрсэн 3 алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар үнэт цаасны тооцоог хөөн хянах шаардлагатай.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

1.1. Илрүүлэлт: Бараа материал худалдан авахдаа И баримт авахгүйгээр худалдан авсан зөрчил илэрлээ.

Эрсдэл: Холбогдох хууль тогтоомжийг баримтлах, зардлыг нотлохгүй байх

Өгсөн зөвлөмж Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт, Иж бүрэн байх зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2. Шилэн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Шилэн дансны хуульд заасны холбогдох мэдээллийг мэдээлээгүй 2020 оны 08 дугаар сарын мэдээлэл, нэмэлт санхүүжилтийн орлого, зарлагыг байршуулаагүй байна.

2.2. Эрсдэл: Мэдээллийг ил тод нээлттэй мэдээлэхгүй байх, хуулийн заалтыг мөрдөөгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.5.4-д “улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр” мэдээлэх гэсэн заалтуудыг мөрдөн холбогдох мэдээллийг тухай бүрд мэдээлж хэвших.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3.Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Байгууллагын дотоод хяналт хэрэгжээгүй, санхүүгийн ил тод мэдээлэл хангагдаагүй, үнэт цаасны тооцоо бодолт хангалтгүй, түлш шатах тослох материал, бичиг хэргийн материалын орлого, зарлагын зарцуулалтад дахин хяналт, шалгалт хийх шаардлагатай байна.

3.2 Эрсдэл: Дотоод хяналтын алба дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байх, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, завших, дутах,

3.3 Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 311 дүгээр тогтоолын 1.5-д “энэ журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө”, 3.5-д “дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд 1 доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ”, 3.6-д “дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ” гэсэн заалтуудыг мөрдөөгүй тул дотоод хяналтын баг томилон дээрх алдаа арилгуулан ажиллах

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Улсын бүртгэлийн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/99/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Улсын бүртгэлийн хэлтэс		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үр дүнгийн тайлан алдаатай илэрхийлсэн	198.2	Залруулга хийх	Дарга , нягтлан бодогч	С.Хоролсүрэн Л.Жаргалмаа
2	Тайлант онд ажилчдад цалингийн урьдчилгаа олгоод суутгаагүй, сахилгын арга хэмжээг дутуу суутгасан, үнэт цаасны тооцоог бодсон боловч сумдын улсын бүртгэгч нараас орлого дутуу төвлөрүүлж, авлагаар бүртгээгүйтэй холбоотой зөрчил илэрлээ.	1398.8	Төлбөрийн Акт		
3	Тайлант онд 3 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад нь ээлжийн амралтын тооцоо хийж, амралтын цалин бодож олгоогүйтэй холбоотой 1179,6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн	1168,5	Буцаан олгох акт		
	Төрийн албан хаагчийн өндөр насны тэтгэвэрт гарахад төрийн албанд ажилласан жилийг буруу тооцож тэтгэмж илүү олгосон,	4070.9	Төлбөрийн Акт		
4	Шатах тослох материал орлого, зарлагын зарцуулалтын тайлан гаргаагүй, төлбөрийг төлөхдөө бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэх, бусад нотлох баримтгүй ажил гүйлгээ хийгдсэн, жолоочийн тооцооны хуудсыг жолооч нар нь тухайн сард авсан шатахуундаа тааруулан км бичсэн, нягтлан бодогч нь жолоочийн замын хуудсыг хаана хэний зөвшөөрлөөр ажилласныг тулган баталгаажуулж тооцоог сар бүр, бодоогүй, бичиг хэргийн материалыг хяналтгүй, зориулалт бусаар зарцуулж, сард 50 боодол цаас, 15 ш принтерийн хорыг зарцуулсан 1536,6 мянган төгрөгийн нийт 4345,4 мянган төгрөгийн төсвийн үргүй зардал гаргасан	4345.4	Албан шаардлага		
5	И баримт авахгүйгээр бараа материалын худалдан авалт хийхгүй байх	0	Зөвлөмж өгөх		
6	Шилэн дансны тухай хуульд заасны дагуу 8 сард мэдээлэх	0	Зөвлөмж өгөх		

	мэдээллийг байршуулаагүй, нэмэлт дансны орлого зарлагыг байршуулаагүй				
	Байгууллагын дотоод хяналт хэрэгжээгүй, санхүүгийн ил тод мэдээлэл хангагдаагүй, үнэт цаасны тооцоо бодолт, түлш шатах тослох материал, бичиг хэргийн материалын зардлын орлого, зарлагын зарцуулалт сул	0	Зөвлөмж өгөх		
ДҮН		11181,8			

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР****Х.БОЛДБААТАР****Огноо:2021.02.21****АУДИТЫН МЕНЕЖЕР****А.ЦЭЦЭГСҮРЭН****Огноо:2021.02.21****АУДИТЫН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:****ГЭРЭЭТ АУДИТОР****Б.БАДАМЦЭЦЭГ****Огноо:2021.02.21**